

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

АУДИТЫН КОД: ТӨА-2024/06/НА-СТА-ТӨА

БАРИЛГА ЗАХИАЛАГЧ, ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ-
ЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4.1 Ерөнхий зүйл	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
.....	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.2 Албан шаардлага	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗТХЯ	Зам Тээвэр Хөгжлийн Яам
ЗТХТ	Зам тээвэр хөгжлийн төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tiv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 4/210.
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАРИЛГА ЗАХИАЛАГЧ,
ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ж.БАТТӨГС ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны орлогын төлөвлөгөөний биелэлт 74,6 хувьтай, 26,275.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Орон сууцны барилгын техник хяналтын орлогыг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, тооцоо нийлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,598,185.37	41,935,505.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,540,665.37	36,799,030.31
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	13,540,665.37	36,799,030.31
31210	Төгрөг	13,540,665.37	36,799,030.31
31213	Арилжааны банк дахь харилцах	13,540,665.37	36,799,030.31
33	АВЛАГА	0	455,195.63
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0	455,195.63
35	БАРАА МАТЕРИАЛ	4,057,520.00	4,681,280.00
35400	Хангамжийн материал	4,057,520.00	4,681,280.00
35470	Бусад хангамжийн материал	4,057,520.00	4,681,280.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	25,963,955.99	26,102,048.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	25,963,955.99	26,102,048.34
39200	Биет хөрөнгө	24,629,289.33	25,163,381.69
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	31,596,900.00	35,546,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12,750,609.00	-17,628,016.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,522,500.00	16,964,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,739,501.67	-9,720,001.67
39300	Биет бус хөрөнгө	1,334,666.66	938,666.65
39301	Програм хангамж	3,660,000.00	3,660,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,325,333.34	-2,721,333.35
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	43,562,141.36	68,037,554.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,555,825.54	26,084.46
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,555,825.54	26,084.46
41300	Өглөг	1,555,825.54	26,084.46
41360	Бусад өглөг	1,555,825.54	26,084.46
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	1,555,825.54	26,084.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	42,006,315.82	68,011,469.82
51	Засгийн газрын хувь оролцоо	42,006,315.82	68,011,469.82
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,000,000.00	1,000,000.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	41,006,315.82	67,011,469.82
51210	Өмнөх үеийн үр дүн	45,951,795.62	41,006,315.82
51220	Тайлант үеийн үр дүн	-4,945,479.80	26,005,154.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	43,562,141.36	68,037,554.28

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	235,921,349.00	358,591,404.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	235,921,349.00	358,591,404.44
120	Нийтлэг татварын бус орлого	235,921,349.00	358,591,404.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	235,921,349.00	358,591,404.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	235,921,349.00	358,591,404.44
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	220,866,828.80	332,586,250.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	220,866,828.80	332,586,250.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	220,866,828.80	332,586,250.44
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	220,866,828.80	332,586,250.44
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	219,135,001.58	329,696,788.89
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	59,102.75	0
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	1,672,724.47	2,889,461.55
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	15,054,520.20	26,005,154.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,000,000.00	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	20,000,000.00	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,945,479.80	26,005,154.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00	0	45,951,795.62	46,951,795.62
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,000,000.00	0	41,006,315.82	42,006,315.82
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,000,000.00	0	45,951,795.62	46,951,795.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-4,945,479.80	-4,945,479.80
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,000,000.00	0	41,006,315.82	42,006,315.82
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,000,000.00	0	67,011,469.82	68,011,469.82
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,000,000.00	0	41,006,315.82	42,006,315.82
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	26,005,154.00	26,005,154.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	235,942,387.44	358,591,404.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	235,942,387.44	358,591,404.44
120	Нийтлэг татварын бус орлого	235,942,387.44	358,591,404.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	235,571,349.00	358,586,406.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	235,571,349.00	358,586,406.00
120009	Бусад орлого	371,038.44	4,998.44
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,782,083.26	327,946,237.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,782,083.26	327,946,237.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,782,083.26	327,946,237.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125,503,981.75	179,003,257.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	125,503,981.75	179,003,257.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,434,049.50	49,006,664.24
210201	Тэтгэврийн даатгал	21,375,153.66	49,006,664.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,514,723.96	0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,011,779.17	0
210204	Ажилгүйдлийн даатгал	502,944.79	0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,029,447.92	0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,815,785.00	3,591,730.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	2,815,785.00	3,591,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,012,560.00	23,093,287.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	0	18,673,117.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	3,012,560.00	4,420,170.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,015,707.01	73,251,299.70
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0	21,120,881.26
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	53,015,707.01	52,130,418.44
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,160,304.18	30,645,166.50

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,760,000.00	7,392,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,760,000.00	7,392,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,760,000.00	7,392,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,760,000.00	0
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	0	7,392,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-9,760,000.00	-7,392,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	10,400,304.18	23,253,166.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,145,559.63	13,545,863.81
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,545,863.81	36,799,030.31

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны төсвийн төсөл	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
Орлого	235,937,189.00	329,071,516.00	287,009,214.00	42,062,302.00	87.22
Нийт орлого	235,937,189.00	329,071,516.00	287,009,214.00	42,062,302.00	87.22
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН /урсгал зардал + ХО зардал/	238,460,994.00	319,046,515.00	312,519,639.00	6,526,876.00	97.95
УРСГАЛ ЗАРДАЛ	238,460,994.00	319,046,515.00	312,519,639.00	6,526,876.00	97.95
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,460,994.00	319,046,515.00	312,519,639.00	6,526,876.00	97.95
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	131,809,180.00	210,651,218.00	207,871,397.00	2,779,821.00	98.68
Үндсэн цалин	131,809,180.00	210,651,218.00	164,903,256.00	45,747,962.00	78.28
ХХОАТ	-	-	19,485,781.00	(19,485,781.00)	
НДШ	-	-	23,482,360.00	(23,482,360.00)	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,523,435.00	26,331,402.00	25,524,304.00	807,098.00	96.93
Тэтгэврийн даатгал	11,235,936.00	17,905,354.00	17,356,527.34	548,826.66	96.93
Тэтгэмжийн даатгал	1,321,875.00	2,106,512.00	2,041,944.16	64,567.84	96.93
ҮОМШӨ-ний даатгал	1,057,500.00	1,685,210.00	1,633,555.72	51,654.28	96.93
Ажилгүйдлийн даатгал	264,375.00	421,302.00	408,388.45	12,913.55	96.93
Эрүүл мэндийн даатгал	2,643,750.00	4,213,024.00	4,083,888.33	129,135.67	96.93
Байгууллагын тогтмол зардал	-	1,020,000.00	939,400.00	80,600.00	92.10
Гэрэл, цахилгаан	-	180,000.00	-	180,000.00	-
Түлш, халаалт	-	600,000.00	-	600,000.00	-
Цэвэр, бохир ус	-	240,000.00	-	240,000.00	-
Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	32,540,525.00	32,944,920.00	25,180,607.00	7,764,313.00	76.43
Бичиг хэрэг	2,762,420.00	3,536,000.00	3,528,700.00	7,300.00	99.79
Тээвэр, шатахуун	19,386,250.00	19,923,120.00	15,011,917.00	4,911,203.00	75.35
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,732,855.00	1,360,800.00	1,351,990.00	8,810.00	99.35
Ном, хэвлэл	134,000.00	325,000.00	238,000.00	87,000.00	73.23
Биеийн тамирын уралдаан, тэмцээн	2,310,000.00	-	-	-	
Программ хангамж	880,000.00	-	-	-	
Эрүүл мэнд, тэтгэмж	5,335,000.00	7,800,000.00	5,050,000.00	2,750,000.00	64.74
Эд хогшлын зардал	8,575,000.00	12,220,000.00	8,573,000.00	3,647,000.00	70.16
Эд хогшил худалдан авах	8,575,000.00	10,100,000.00	7,700,000.00	2,400,000.00	76.24
Нормын хувцас, зөөлөн эдлэл авах	-	2,120,000.00	873,000.00	1,247,000.00	41.18
Томилот, зочны зардал	15,972,700.00	19,522,000.00	17,262,000.00	2,260,000.00	88.42
Дотоод албан томилолт	11,562,100.00	15,562,000.00	13,372,000.00	2,190,000.00	85.93
Хичээл, сургалт, семинар, хурал, зочны зардал	4,410,600.00	3,960,000.00	3,890,000.00	70,000.00	98.23
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,442,004.00	16,356,975.00	25,613,105.00	(9,256,130.00)	156.59
Техникийн нөхцөл, магадлал	2,742,464.00	5,090,400.00	3,127,820.00	1,962,580.00	61.45
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	588,000.00	588,000.00	806,400.00	(218,400.00)	137.14
Тээврийн хэрэгслийн зардал	3,390,000.00	3,235,000.00	4,716,325.00	(1,481,325.00)	145.79
Зар сурталчилгааны зардал	3,935,200.00	3,740,000.00	2,500,000.00	1,240,000.00	66.84
Дансны шимтгэл	57,200.00	100,000.00	75,100.00	24,900.00	75.10
Газрын төлбөр	1,729,140.00	3,603,575.00	14,387,460.00	(10,783,885.00)	399.26
Автомашин акталсан	20,000,000.00	-	-	-	

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, ҮР ДҮН	(2,523,805.00)	10,025,001.00	(25,510,425.00)	35,535,426.00	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	-	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	10.00	12.00	10.00	2.00	
Удирдах ажилтан	-	1.00	1.00	-	
Гүйцэтгэх ажилтан	7.00	9.00	7.00	2.00	
Үйлчлэх ажилтан	2.00	2.00	2.00	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Барилга захилагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын зорилго нь: “Барилгын зураг төсөв, техникийн норм, дүрмийг дагаж мөрдүүлэх, зөв зохистой төлөвлөн зарцуулах, чанартай материал хийц эдлэлээр барилга бариулах, орон нутгийн иргэдийг орон сууцжуулах талаар баримтлах бодлого стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх” гэж тодорхойлжээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит ААТҮГ азар статустай аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын харьяа байгууллага байна.

Үйлдвэрийн газрын дүрэмд ” Газрын /ОНӨААТҮГ-ын өмчлөгч нь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь аймгийн засаг дарга болон үйлдвэрийн газрын удирдах зөвлөл байна” гэж тодорхойлжээ. Үйлдвэрийн газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Бүтээн байгуулалт, барилгын ажлын зураг төсөв, санхүүг зохистой төлөвлөн зарцуулах чанартай хийц эдлэлээр барилгыг бариулах;
- Зураг төсөв, техникийн норм дүрмийг дагаж мөрдүүлэх болон далдлагдах ажлыг шалгах баталгаажуулах;
- Барилга байгууламжийн гүйцэтгэгч байгууллагаас гаргасан зөрчил , дутагдлыг засуулах ажлын гэрээт хугацааг чанд мөрдүүлэх;
- Барилга байгууламжийг чанартай ашиглалтад оруулахад техникийн хяналт тавихаас гадна холбогдох байгууллага, аж ахуйн нэгжтэй ерөнхий захирагчийн өмнөөс үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, орон нутгийн иргэдийг орон сууцжуулах талаар баримтлах бодлого, стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- Зуунмод хотын газрын нөөцийг үр ашигтай төлөвлөн эргэлтэд оруулах замаар хотын суурьшлын бүсийг хөгжүүлэх, бага , дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах, орон сууцны нөхцөлийг сайжруулах, орон сууц нийлүүлэх, ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах; зэрэг аймгийн орон сууц, дахин төлөвлөлтийн асуудлыг нэгтгэн зохион байгуулах;

3.2 Барилга захилагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ыг Төв аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 121 дүгээр тогтоолоор, “Төв аймгийн орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-т нэгтгэн “Төв аймгийн барилга захиалагч, орон сууцны корпораци орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, газрын дүрэм, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4- т ”Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан

буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.;...” гэсэн заалттай нийцэж байна.

"Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна.

Тайлант хугацаанд Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт дараах өөрчлөлт орсон байна.Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.

- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн;

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д” Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”;

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол;

- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нөлөөгүй байна.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын дүрмийн 3.4-т” Үйлдвэрийн газар нь үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэж , ажиллах журмыг Удирдах зөвлөл батална “ гэж заасан байна. Дотоод хяналтын багийн ажиллах журам, ажлын төлөвлөгөөг батлаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлангүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24,470.2 мянган төгрөгөөр буюу 50%-аар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,545.8	36,799.0	23,253.2
Авлага	0.0	455.2	455.2
Бараа материал	4,057.5	4,681.2	623.7
Урьдчилж төлсөн зардал			
Дуусаагүй үйлдвэрлэл			
Үндсэн хөрөнгө	25,963.9	26,102.0	138.1
Нийт хөрөнгө	43,567.3	68,037.5	24,470.2
Өр төлбөр	1,561.0	26.0	-1,535.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	42,006.3	68,011.4	26,005.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	43,567.3	68,037.5	24,470.2

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийндансны үлдэгдэл өмнөх оноос өсөж, өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 23,253.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд техникийн хяналтын орлого өссөнтэй холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 623.7 мянган төгрөгөөр өссөн нь 28,250.6 мянган төгрөгийн хангамжийн материал бэлтгэн, 27,626.9 мянган төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 138.1 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр 7,392.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, элэгдлийн зардал гарсантай холбоотой байна.
- Өр төлбөрийн үлдэгдэл 1,535.0 мянган төгрөгөөр буурсан нь Татварын хэлтэст төлөх ААНБ-ын орлогын албан татварын өглөг үүссэнээс шалтгаалжээ.

- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 26,005.1 мянган төгрөгөөр өссөн нь ашигтай ажилласан нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 329,071.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 319,046.5 мянган төгрөгөөр, 10,025.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Нийт орлогын гүйцэтгэл 287,009.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 42,062.3 мянган төгрөгөөр буюу 12.8 хувиар буурсан нь үндсэн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт нөлөөлсөн байна. Нийт зардлын гүйцэтгэл 312,519.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 6,526.8 мянган төгрөгөөр дутуу буюу 97.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой үйл ажиллагааны орлогын бүртгэлтэй албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 235,921.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,538.8 мянган төгрөгөөр тогтоосны 75 хувиар гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2,654.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ тайлант онд 12 орон тоотой ажиллахаас 10 орон тоогоор ажиллаж цалин, НДШ-ийн зардлыг хэмнэн, гар утасны ярианы төлбөрт зардал гаргаагүй ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 182 мэдээлэл байршуулахаас 173 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 9 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Байгууллагын эзэмшилд байгаа 8 газрыг Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг зөрчин эзэмшүүлсэн байна. Уг асуудлын Газар олголт, эрх шилжүүлсэн байдлын талаар хийгдэх гүйцэтгэлийн аудитаар авч үзэхээр болсон.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2023 оны гуравдугаар улирлын байдлаар завсрын аудит хийж, аудитаар 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 төлбөрийн акт, 1 зөвлөмжийг 100% хэрэгжүүлэн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлын 2023 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн 116 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	404.2	3	404.2	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1	2,000.0	1	2,000.0	100
Нийт дүн	4	2404.2	4	2404.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар байгууллагын эзэмшилд байгаа газрын талаар авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,506.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 39,297.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

Орон сууцны барилгын техник хяналтын орлогыг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, тооцоо нийлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтууд болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодогдсон	1	1,506.8	1	1,506.8			1	1,506.8				
Дүн	1	1,506.8	1	1,506.8			1	1,506.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орон сууцны барилгын техник хяналтын орлогыг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, тооцоо нийлээгүй байна.	1	39,297.5			1	39,297.5		
Дүн	1	39,297.5			1	39,297.5		